

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-11

---

- 1. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 4-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 24 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн;  
Чөлөөтэй: Х.Баттулга, П.Батчимэг, Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл,  
Б.Найдалаа, О.Цогтгэрэл;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Ганхуяг, М.Мандхай.

**Нэг. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, А.Мандуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Ш.Ганхуяг, мөн газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Усны газрын дарга З.Батбаяр, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, мөн компанийн ахлах геологич А.Алтанхундага нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, мөн албаны референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгийн ахлагч Б.Пүрэвдорж “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэсэн Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан заалтыг тогтоолын төслөөс хасах гэсэн горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Байнгын хорооны дарга Р.Сэддорж нар үг хэлэв.

Горимын саналтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэсэн Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан заалтыг тогтоолын төслөөс хасах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	3
Бүгд:	15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 27 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 51 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 12 цаг 24 минут

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Гишүүд суудлаа эзэлье. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүд гишүүдийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батсүмбэрэл, Лувсанжамц, Сэддорж, Энхцэцэг, Батболд, Жаргалан, Сайнзориг, Цэнгүүн, Батнайрамдал, Лодойсамбуу, Соронзонболд, Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Одоогоор албан ёсоор чөлөөтэй гишүүд Баттулга гишүүн чөлөөтэй байна. Батчимэг гишүүн чөлөөтэй байна. Ганхуяг гишүүн эмнэлгийн чөлөөтэй. Мандхай гишүүн эмнэлгийн чөлөөтэй. Мөнхсоёл гишүүн чөлөөтэй байна.

Хуралдааны ирц 52 хувьтай байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Уг тогтоолын төслийг Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Хэлэлцэх асуудал нэг. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.**

Тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Пүрэвдорж гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал, Бат-Эрдэнийн Хулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангай Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Шаравдоржийн Ганхуяг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Зэнээмядарын Батбаяр Усны газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Лхагвасүрэнгийн Жаргалсайхан ШУА-ийн Хими химийн технологийн хүрээлэнгийн захирал, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” Компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Лувсаншаравын Наранчимэг “Эрдэнэс Монгол” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Цэдэнбалжирын Төгсбуян “Эрдэнэс Монгол” компанийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах “Эрдэнэс Монгол” компанийн хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Доржбалын Далайжаргал “Мон-Атом” компанийн захирал, Амарсанаагийн Алтанхундага, “Мон-Атом” компанийн ахлах геологич, Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич профессор, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батхүлэг Дотоодын хуулийн зөвлөх.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгөөрэй. Алга байна.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудалд Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр Бадамсүрэн гишүүн горимын санал гаргаж бас яг энэ 30 хувийг орон нутагт өгөх тухай АМНАТ-аас орж байгаа орлогын 30 хувийг орон нутагт олгох тухай ийм санал гаргасан. Тэгэхээр энэ саналаа Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдад бас даалгах тогтоолд 1 заалт оруулсан байгаа. Тэгэхээр энэ заалтыг бол Ашигт малтмалын тухай хуулиар бас тодорхой хэмжээгээр зохицуулаад даалгахгүйгээр, ашигт малтмалын хууль дээр манай ажлын хэсэг гарчихсан. Тэр дээр ажиллаж байгаа. Тэрүүгээр ер нь бол шууд хууль болгож оруулах талаар ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгэхээр даалгаад ингээд орчихоор яг ажил чинь бас хийгдэхгүй байгаад байна шүү дээ. Тийм учраас энэ заалтыг яг энэ агуулгатай бас бүрэн нийцэхгүй, хэлэлцээр болон бусад зүйлд яг орж ирээгүй ийм заалт орж ирэхээр нөгөө хөрөнгө оруулагч тал маань бас тодорхой хэмжээгээр гайхах ийм тал гарч ирж байна.

Яагаад гэвэл бид нар АМНАТ-аасаа авч байгаа орлогоо дотооддоо л бид нар өөрсдөө зохицуулах боломжтой. Энэ бол хэлэлцээрт ямар ч хамаагүй зүйл. Тийм учраас энийг өөр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тодорхой хэмжээгээр зохицуулах боломжтой гэж үзэж байна. Тийм учраас энэ заалт бас тодорхой хэмжээгээр хэлэлцээрт нөлөөлөх, бусад төсөл, хөтөлбөрт нөлөөлөх ийм магадлал өндөр байгаа тул горимын санал гаргаж байна.

Бадамсүрэн гишүүний гаргасан заалтыг хүчингүй болгох ийм санал гаргаж байна. Энийг дахин хэлэлцэж өгнө үү. Тэгээд дээрээс нь манай Тэлмүүн бас тодорхой тайлбарыг нь хийгээд өгчих. Энэ ямар учиртай болох талаар.

**Р.Сэддорж:** Ажлын хэсэг 1 номер.

**Б.Тэлмүүн:** Сангийн яам Тэлмүүн. Нэмэлт тайлбар өгье. Сая хураагдсан санал бол нэлээн эрх зүйн нарийн үр дагавартай санал байгаа.

1 дүгээрт Засгийн газарт даалгасан ийм чиглэл бол тухайн төслийн стратегийн ордын 30 хувийг заавал орон нутагт хуваах асуудлыг бол Улсын их Хурал зарчмын хувьд дэмжсэн гэсэн агуулга. Тэгэхээр энэ бол гаднын хөрөнгө оруулагч талдаа болон одоо хэрэгжиж байгаа энэ стратегийн төслүүд дээр нэг бол энэ хүмүүс татвар нэмэх гэж байна Монгол Улсын Их Хурал, нөгөө талдаа орон нутагт нийгмийн хариуцлагын хүрээнд авдаг төлбөрүүдийг нэмэх гэж байна гэдэг ийм ойлголтыг шууд өгч байгаа.

Хэлэлцээрийн явцад Францын талтай ярьж байгаа хэлэлцээрийн явцад бол бид бүх татвар хураамж бол одоогийн хууль тогтоомжийн хүрээнд дээрээс нь бид нар өсөн нэмэгдэх АМНАТ тусгай рояалтыг бол ингээд оруулж ирж байгаа. Орон нутагт бол бид жил болгон 1 сая доллар гэдэг ийм байдлаар бол хэлэлцэн тохироод ингээд боогдож орж ирсэн. 30 хувь гэдэг асуудал орж ирэх юм бол шууд нөгөө талдаа орон нутгийн авах тэр нийгмийн хариуцлагын хүрээнд авах хөрөнгө

оруулалт, эсвэл татварыг нэмэх асуудал энд ингээд яригдчихлаа. Дахиж энэ хуулиуд өөрчлөгдөх юм байна гэдэг ийм хүлээлт үүсгэнэ.

2 дугаарт нь Монгол Улс нэгдсэн төсөвтөө орж ирсэн татварын болон татварын бус орлогоо дотроо яаж хуваарилах нь бол төсвийн тухай хуулиар зохицуулагддаг. Энэ хэлэлцээр гаднын хэлэлцээртэй холбоогүй асуудал. Тэгэхээр энэ асуудлыг бол Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга, Татварын хууль тогтоомжийн өөрчлөлт, дээрээс нь төсвийн хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор бид дотроо ярих асуудал байгаа. Тэгэхээр энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай ингээд ороод ирэхээр энэ өөрөө хэлцэл задрах хүртэлх ийм эрх зүйн үр дагавартай, эрсдэлтэй асуудал болчихоод байгаа юм.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналын дагуу “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймаг сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэсэн Бадамсүрэн гишүүний гаргасан заалтыг тогтоолын төслөөс хасах гэсэн горимын санал гаргасан байна.

Энэ томъёоллоор санал хураалт явуулна. Санал бол 3-ны 2-оор дэмжигдэнэ. Санал хураалт. Учрал сайд тайлбарлах уу. Учрал сайд 3 номер. Гишүүдэд ойлгомжтой, товч тайлбар.

**Н.Учрал:** Энэ бол Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулж байгаа л тогтоол. Нэг ёсондоо энэ дээр тухайлан Дорноговь аймгийн энэ 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд тэр давуу эрхийн хувьцаа тусгай АМНАТ-аар орлуулсан л тогтоол. Гэтэл яг энэ тогтоолын үзэл баримтлалаас ангид нөгөө стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймаг сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилна гэхээр энэ хэлэлцээрийн явцад нөгөө хөрөнгө оруулагч тал бол энийг одоо ингээд орон нутгийн хөгжлийн санд мөнгө нэмж авах гээд байна гэж ойлгох ийм эрсдэл үүсээд байгаа юм. Дээрээс нь энэ асуудал дээр биш, энэ тогтоол бол бүхэлдээ нөгөө стратегийн ач холбогдол бүхий нөгөө 16 ордыг эзэмшиж байгаа компаниудын 34 хувийн хэлэлцээрт шууд нөлөөлөх, дээрээс нь энэ чинь өөрөө дотоодын бидний төсвийн хуваарилалтын асуудал байхгүй юу. Түрүүн хэлсэн нөгөө 65 хувийн АМНАТ-ыг Ирээдүйн өв санд аваад, тусгай АМНАТ-ыг хуримтлалын санд аваад ингээд хуулийн дагуу хуваарилагдаж байгаа асуудал дээр 30-аас доошгүй хувийг нөгөө сөрөг нөлөөлөл өртөж байгаа орон нутагт өөгөөрэй гээд ингэчихээр энийг бас шууд хөрөнгө оруулагч тал буруу ойлгох, тэгээд хэлэлцээрт нөлөөлөх ийм эрсдэл үүсээд байгаа юм.

Тэрнээс биш Бадамсүрэн гишүүний гаргаад байгаа санал бол маш зөв. Энэ байгалийн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймаг, сумуудад ялгамжтай байдлаар хуваарилах энэ асуудлыг бид нар Ашигт малтмалын хуулиар бүхэлд нь шийдэж өгөх ёстой. Тэгэхгүй ингээд тэнц тэнцүү ингэж хуваарилж угаасаа болохгүй байхгүй юу. Тийм учраас Засгийн газраас энэ Ашигт малтмалын хуулийг өргөн мэдүүлээд, үүнийг бүр тухайлан ингэж ялгамжтайгаар зааглах, энэ хуваарилалтыг оновчтой болгох эрх зүйн үндсийг бол бид нар бий болгоно. Гэхдээ энэ тогтоол дээр бол эрх

зүйн үндсийг бий болгох чиглэлээр арга хэмжээ аваарай гээд заачихсан хэдий ч нөгөө хөрөнгө оруулагч талтай яг ийм хэлэлцээ явж байгаа ийм эмзэг цаг үед бас хөрөнгө оруулагч талдаа буруу ойлголт өгөөд, арай гэж тохирсон нөгөө орон нутгийн санд авах хэдэн төгрөгөө арай гэж тохирчхоод байгаа. Нөгөө хэлэлцээрээ нөгөө 50 дээр нэмэх 1-ээ хангуулах зарчмаа алдчих вий гэдэг ийм болгоомжлол байна.

Тэгээд хөрөнгө оруулалтын гэрээ гэдэг бол энэ чинь бас 2 талын эрх ашиг хангагдаж байгаа учраас бид бас хэлсэн ярьсандаа арай гэж тохирсон заалтуудаасаа ухарчихгүй юм сан гэдэг ийм л болгоомжлол байгаа учраас Бадамсүрэн гишүүнийг үүнийг бас ойлгож хүлээж аваасай гэж хүсэж байна.

**Р.Сэддорж:** Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүний хувьд та бүхний тайлбарыг сонслоо. Ер нь яах вэ стратегийн ач холбогдолтой ашигт малтмал дотор бол юу орж байна гэхээр газрын ховор элемент цаашдаа орох ёстой. Өсөн нэмэгдэж байгаа, үнэ цэнтэй болж байгаа уран орж байгаа хэмжээнээс үл хамаараад тэгээд цаашдаа газрын тос гээд ингээд үнэ цэнтэй ийм чухал ашигт малтмалууд бол цаашдаа орох ёстой л доо. Тэгэхээр яах вэ, энэ бол миний хувьд Дорнод аймгийн Засаг даргаар 9 жил ажиллачихсан хүний хувьд бол энэ орон нутагт уул уурхайн салбарын өгөөж, тэр насаараа нутагласан ард иргэдэд, малчин иргэдэд очоосой л гэж байгаа юм. Яагаад гэхээр тэнд зөвхөн байгаль орчин, зам тоосжилтоос гадна тэр хүмүүсийн сэтгэл зүйд хүртэл маш их хэмжээний сөрөг нөлөөлөлд өртөж байгаа. Жишээлбэл Дорнод аймагт, Өмнөговь аймагт гэхэд л гадаадын иргэд ерөөсөө бараг эзэлчихсэн байдаг юм шиг хүртэл хүмүүсийн сэтгэл зүйд нөлөөлж байгаа. Тэгээд би бол Засгийн газрын бодлого, гэрээ хэлцлийг ойлгож байна. Гэхдээ яг орон нутагт хөрсөн дээрээ ард иргэдэд тулгамдаад байгаа асуудал бол үнэхээр хүнд байгаа шүү. Тийм учраас энийг бүхий л түвшиндээ маш сайн ойлгох хэрэгтэй. Тэгээд яах вэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, сайдын байр суурийг ойлгож байна.

Хэрвээ энэ тохиолдолд бол Байнгын хорооноос чиглэл өгөөсэй гэж хүсэж байна. Би Байнгын хорооны даргад, яагаад гэхээр Ашигт малтмалын тухай хууль болон Төсвийн тухай хуульд энэ орон нутагт роялтигийн хуваарилалтыг 20 хувиас доошгүй гээд хуулийн төсөл дээр явж байгаа юм байна лээ. Тэгээд энийг олон улсын жишгийн дагуу 30-аас доошгүй хувь гээд энийг оруулна гэдэг энэ амлалтыг ажлын хэсгийн дарга Пүрэвдорж дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд нар өгөх ёстой гэж бодож байна. Өгөөд харин Байнгын хорооноос үгүй ээ, та ажлын хэсгийн дарга шүү дээ. Та хамгийн их нөлөөлөөд байгаа болохоор би танд хэлж байгаа байхгүй юу. Тийм учраас ингээд явбал энэ яах вэ, Монголчуудад л хэрэгтэй. Насаараа нутаглаж байгаа өмнийн говьд байгаа баруун, зүүн, хойд хязгаарт байгаа тэр малчин түмэн, орон нутгийн ард иргэдэд л хэрэгтэй зүйл болохоос биш энэ бол хэн нэгэн хувь хүний ямар ч одоо эрх ашиг байхгүй шүү дээ. Тэгээд яг амьдрал дээр очоод энэ төслийг хэрэгжүүлнэ гэхэд бол маш их эсэргүүцэлтэй тулгарна шүү. Тийм учраас энэ зүйл дээр амжилттай хэрэгжүүлэхийн тулд уул уурхайн өгөөж нь тэр орон нутагтаа очдог. Ард иргэд нь адилхан хөгждөг байхын хувьд л энэ саналыг гаргаж Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр анхны хэлэлцүүлгээр Их Хурлын чуулганд бүх гишүүд 126 гишүүний Монголын ард түмний төлөөлөл дэмжсэн санал байхгүй юу. Тэгэхээр би Байнгын хорооноос ийм одоо чиглэл өгсөн тогтоол гардаг юм уу. Горимын санал ингээд

гаргаж байгаа юм чинь Пүрэвдорж дарга. Тэрэнтэй адилхан тэгээд ийм амлалтаа бас 2 дарга өгөөд тэгээд явбал яасан юм бэ гэсэн бас адилхан горимын саналтай байна.

**Р.Сэддорж:** Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр яг говиос гишүүн болсон Наранбаатар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг Ашигт малтмалын хууль дээр ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дээр бол яг таны гаргаж байгаа тэр АМНАТ-аас орж байгаа орлогын 30 хувийг орон нутагт өгөх ёстой гэдэг энэ заалтыг дэмжиж оруулахын төлөө бид нар ажиллана 1 дүгээрт.

2 дугаарт хэрвээ энэ Ашигт малтмалын тухай хууль орж ирэхгүй бол энэ асуудлыг яаж шийддэг юм бэ гэхээр бас Төсвийн хуулийг дагуулж хийж болдог. Тийм учраас төсвийн тодотгол явах юм уу, аль эсвэл 2026 оны төсвийн хууль явах тохиолдолд бол яг энэ асуудлыг Учрал сайд яг тэр заалтыг дагуулж оруулж ирээд та тухайн үед нь сайн хэлээрэй. Тэгээд түүний дагуу бас энэ асуудлыг шийдэж болдог юм. Тийм учраас энэ бол бид нар энэ авчихсан АМНАТ-аа Монголын орлого болчихсон тэр орлогоо бид нар дотооддоо яаж хуваарилах нь манай дотоодын асуудал учраас таныг энэ саналыг дэмжээд, бас яг энэ Учрал сайд бид 2 энэ дээр бас нэлээн сайн ажиллана. Тэгээд энэ хэлэлцээрт нөлөөлөх энэ саналыгаа бас татаад авчхаач гэж хүсэж байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Учрал сайд 3 номер.

**Н.Учрал:** Би Бадамсүрэн гишүүний саналыг бол үнэхээр 100 хувь дэмжиж байгаа. Орон нутгийн хөгжлийг дэмжих ёстой. Тийм учраас энэ хөрөнгө оруулалтын гэрээ дээр орон нутгийн хөгжлийг дэмжих гэдэг ийм бүлэг оруулаад, энэ хөрөнгө оруулалтын гэрээ жишиг болно. Яагаад гэвэл тэр 5,2 тэрбум долларын 1 тэрбум доллар нь орон нутагт орох байхгүй юу. Дээрээс нь Баялгийн сангийн хуулийн дагуу өсөн нэмэгдэх АМНАТ энэ удаа анх удаа яригдаж байгаа учраас өсөн нэмэгдэх АМНАТ ч бай, суурь АМНАТ ч бай 65 хувийн үлдсэн хэсэг нь орон нутгийн сан руу явна. Тэгэхээр 5 тэрбум долларын 1 тэрбум долларыг нь орон нутагт авах гээд байна. 1600 хүн ажиллахаас бараг 1600 хүний чинь ажлын байрыг бий болгох гээд байна. 40 хувийг нь тэр сумаас авах гээд байна. Тэгэхээр энэ удаа орон нутаг дээр бүр яг нэлээд шахаж байж энэ хэлэлцээг явуулаад орон нутгийг дэмжих гээд байгаа юм. Дээрээс нь тэнд дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийгдлээ гэхэд түүнийгээ тэд аваад явахгүй. Орон нутагт нь шилжүүлж өгөх зохицуулалтыг хийсэн. Дээрээс нь тэр одоо хүртэл 4 жилд 1 жил болгон тэрбум төгрөг өгөөд байгаа. Дээрээс нь бүтээн байгуулалтын үе шатад буюу уурхайн ашиглалт эхэлсний дараа 1 сая доллар авах гээд байгаа. Тэгэхээр тэр 1 сая долларыг аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга хамтраад зөвлөлөөрөө оруулаад юунд зарцуулахаа шийдэх гээд байгаа. Энэ хөрөнгө оруулалтын гэрээ орон нутгийг дэмжиж байгаа гэрээ. Тэгэхээр нөгөө энэ ганц заалттай энэ тогтоол батлагдсанаараа бид нар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд гэрээний сүүлийн драфтыг зөвшилцөхөөр хүргүүлэх гээд та бүхэнд илгээсэн шүү дээ. Тэгэхээр энэ тогтоол батлагдаж байж л хөрөнгө оруулалтын гэрээ зөвшилцөх болох гээд байхад энэ дээр нэг ийм өөр заалт орчихоор нөгөө тогтоолын үзэл баримтлалаа зөрчих гээд байгаа болохоос биш, орон нутгийг хэн нь дэмждэг, дэмждэггүй хэлэлцүүлэг энд бол хийж ерөөсөө болохгүй байна. Тийм учраас бас

гишүүд бүгдээрээ л орон нутгаа дэмжье л гэж байгаа юм. Би ойлгож байгаа. Тийм учраас энд тохирохгүй байна.

Харин ирэх 7 хоногт би бас Байнгын хорооны даргад бас санал тавья. Би Туваан сайдтай хамт орж ирээд, Засгийн газарт чиглэл өгсөн ийм 1 тогтоол гаргаад өгчих. Тэгээд би тэд нар, Засгийн газар тэр тогтоолоо бариад, тогтоолынхоо хүрээнд хавар хүртэл ажиллалчихъя. Тэрнээс биш нөгөө гэрээг явуулах гэж байгаа хөрөнгө оруулалтын гэрээг явуулах гэж байгаа энэ Их Хурлын тогтоол дотор ийм заалт орчихоор нөгөө хөрөнгө оруулагч нарт чинь сюрприз байхгүй юу. Одоо ямар бас ээлжит сюрприз барчхав гэж. 27 жил сюрприз барьчихсан шүү дээ бид нар. Тэгэхээр бас одоо эд нар чинь нөгөө адаг сүүлд нь гэнэт нэг юм оруулж ирээд бас юу болгоод хаячхав гээд энийг чинь ойлгуулах гэсээр байтал бас юу болж өнгөрөхийг бол мэдэхгүй учраас ирэх 7 хоногт Байнгын хороо дээр Туваан сайдыг хамт авч орж ирээд, тэгээд бид Засгийн газарт чиглэл өгсөн тогтоол та бүхэн батлаад өг. Тэгээд хавар хүртэл бид нар ажиллая. Тусад нь батлаад өг л гэж хүсмээр байна.

**Р.Сэддорж:** Ирэх 7 хоногийн Байнгын хорооны хурал дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэдээлэл байгаа. Тэр хойшилчихсон байгаа юм. Тэр мэдээллийг сонсоод, тэгээд энэ дээр тогтоолоо гаргахаар шийдье. Бадамсүрэн гишүүн тэр дээр саналаа гаргахыг хүсэж байна.

Ингээд Бадамсүрэн гишүүний яриад байгаа юм чинь бол ер нь тодорхой шүү дээ. Энд Ашигт малтмалын хууль дээр бүх юм шийдчихсэн гээд яриад байгаа боловч яг хачир дээрээ уурхай нээхээр манай аймагт, сумд ашиггүй юм байна гэдгийг, нэмэргүй юм байна гэдгийг ард түмэн яриад байгаа байхгүй юу. Багийн дарга нь ч ярьж байгаа. Сумын дарга нь ч ярьж байгаа. Тэгэхээр одоо бол цаашдаа уул уурхай яаж явах вэ гэхээр энэ хуулийн өөрчлөлтөө маш чамбай бүр багийн Иргэдийн Хурлаас асуудаг байснаа ч больж байгаа. Үндэслэлтэй, хуулийн үндэслэлтэй заалт явуулахгүй бол шууд дээрээс лицензийг өгдөгт бол ард иргэд үнэхээр эгдүүцэж байгаа юм. Тэгээд энэ хэлээд байгаа зүйл тэгээд тухайн уурхай байгуулагдаад иргэдийн тэр махыг нь ч авахгүй, сүүг нь ч авахгүй, махыг нь аваад орлого оруулахгүй, сүүг нь ч авахгүй, тэр сумын дэлгүүрээс бараа бүтээгдэхүүн юу ч авахгүй. Тэгээд ингэхээр чинь бол иргэд чинь бол энэ дээр үнэхээр худлаа юм байна гэдэг ийм зүйл яриад байгаа шүү дээ. Тэгээд усыг нь баяжмал угаана. Гүний усыг нь баяжмал угаана. Ундны усных нь хэрэгцээг хангахын төлөө юу ч хийхгүй. Тэгээд ийм харгис шинжтэй зүйл компаниуд ажиллаж эхлээд байгаа учраас Бадамсүрэн гишүүн болон орон нутгаас гарч ирж байгаа саналууд бол ингээд энэ хууль дээр чинь ерөөсөө хангалтгүй байна гэж үзээд л энэ тогтоол дээр оруулъя гэж зүтгээд байгаа гэж ойлгоорой.

Ингээд саяын Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт. Санал татах зүйл бол байхгүй юм байна. Шууд санал хураалт. Санал хураалт. Бадамсүрэн гишүүн үгээ хэлчих. Протоколд тэмдэглүүлчих.

Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд оролцсон гишүүдэд баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

12.51 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*